



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/136

Дуурсах

"Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
чанар, аюулгүй байдлыг сайжруулах"
аян, сургалт зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" А/136 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2022 оныг "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил" болгон зарласантай холбоотой "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 20-21, аяныг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Аян, сургалтын удирдамжийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, аян, сургалтад зарцуулах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аян, сургалтад зарцуулагдах 960.500 (есөн зуун жаран мянга таван зуун төгрөг)-ийг нэмэлт санхүүжилтийн зардлаас зарцуулахыг Ахлан нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ) -д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй зохион байгуулан тайлагнахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (С.Батцэцэг), Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн (О.Найгалмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
05 дугаар сарын 24-ний өдрийн А/42
тушаалын нэгдүгээр хавсралт

**"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ" АЯН, СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Эрүүл мэндийн тусламжийн чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлын асуудалд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ихээхэн анхаарал хандуулж "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үндсэн хэмжигдэхүүн" гэж тодорхойлсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хэн, хаана амьдарч байгаагаас үл хамааран бүхий л иргэд үйлчлүүлэгчийн хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах явцад учирч болох аливаа хохирол, эрсдэлийг 2030 он хүртэл шат дараатайгаар бууруулах замаар тусламж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2021-2030" хөтөлбөр батлагдсан нь салбарын хэмжээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр баримтлах үндсэн баримт бичиг болж байна. Чанар, аюулгүй байдлын асуудал нь тасралтгүй сайжруулах, үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үйл явц байдаг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2021 оны судалгаагаар 10 үйлчлүүлэгч тутмын 1 нь эмнэлгийн ямар нэг алдаа зөрчилд өртөж, дунд болон бага орлоготой улс орны эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээнээс үүдсэн 134 сая алдааны тохиолдол гарч, жил тутам 2,6 сая эндэгдэлд хүргэж байгаа тухай дурдсан байдаг.

Иймд удирдлагын манлайлал, дэмжлэг, зохион байгуулалт хариуцлагыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, олон улсын жишигт ойртуулан хэрэгжүүлэх нь "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил"-ийн үндэслэл болно.

Хоёр. Зорилго

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд тусламж, үйлчилгээг үр ашигтай, тэгш хүртээмжтэй хүргэхэд удирдлагын манлайлал, дэмжлэгийг нэмэгдүүлэн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг ханган, чанарыг сайжруулах



Гурав. Зорилт

3.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах

3.2 Эрүүл мэндийн байгууллагын санал санаачлагыг дэмжих

3.3 Сайн туршлага сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

3.4 Үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн салбар бий болох

Дөрөв. Хамрах хүрээ

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 121 аж ахуйн нэгж байгууллагууд

Тав. Хугацаа:

- Сургалт 2022 оны 05 дугаар сарын 20-21 өдрүүдэд
- Аян өрнүүлэх хугацаа 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл
- Аяны тайлан ирүүлэх хугацаа 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор
- Аяны дүгнэх шалгаруулах хугацаа 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Зургаа. Хаана: Сургалт аймгийн Засаг даргын тамгын газрын зааланд 9 цагт

Долоо. Хүрэх үр дүн

Чанарын тухай үндсэн ойлголт, үзэл баримтлал, зарчимуудын талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгслүүдийн тухай мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналт, үнэлгээ, дотоод хяналтыг хэрхэн зохион байгуулах талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах аргад суралцсан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйд суралцана.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ зэрэгт мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал сайжирсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын *О.О.О* оны
А.А.А дугаар сарын *05-05* өдрийн
А.А.А дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

| № | Сургалтын сэдэв | Хугацаа | Хариуцах нэгж, хүн |
|---|--|---------------------|--|
| Эхний өдрийн сургалт (05 сарын 20) | | | |
| 1. | Сургалтын нээлт, танилцуулга | 09.00 -09.10 | Чиглүүлэгчид |
| 2. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл (2022-2026) | 09.10- 09.40 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр Э.Тунгалаг |
| 3. | Мгадлан итгэмжлэлийн журам, шалгуур үзүүлэлт, бэлтгэл үйл явцын шинэчлэлтийн талаархи танилцуулга | | |
| 4. | Сургалтын өмнөх сорил | 09.40-09.45 | Чиглүүлэгчид |
| 5. | Чанарын тухай үндсэн ойлголт, үзэл баримтлал, зарчимууд | 09.45 -10.30 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр М.Оюунчимэг |
| 6. | Шийдвэрлэх асуудлыг илрүүлэх, шалтгаан хамаарлын дүн шинжилгээ хийх | 10.30 -11.15 | |
| Цайны завсарлага | | 11.15-11.30 | |
| 7. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгслүүд | 11.30 – 12.10 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр Э.Тунгалаг |
| 8. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгслүүд /дадлага ажил/ | 12.10– 13.00 | |
| Үдийн хоолны завсарлага | | 13.00 –14.00 | |
| 9. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах “COPE” арга | 14.00 –14.45 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр М.Оюунчимэг |
| 10. | Аюулгүй байдлын тухай ойлголт, үзэл баримтлал | 14.45 – 15.30 | |
| Цайны завсарлага | | 15.30-15.45 | |
| 11. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын ОУ-ын зорилт /МИ-ийн шалгуур/ | 15.45 – 16.30 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр Э.Тунгалаг |
| 12. | Сургалтын талаархи ярилцлага | 16.30 -17.00 | Чиглүүлэгчид |
| Хоёр дахь өдрийн сургалт (05 сарын 21) | | | |
| 13. | Эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналт, үнэлгээ, дотоод хяналт | 09.00 - 09.45 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр Э.Тунгалаг |
| 14. | Эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналт, үнэлгээ, дотоод хяналт /дадлага ажил/ | 09.45 –10.30 | |
| 15. | Эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах | 10.30 – 11.15 | |

| | | | |
|--------------------------------|---|----------------------|--|
| | | | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр М.Оюунчимэг |
| Цайны завсарлага | | 11.15 – 11.30 | |
| 16. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах | 11.30 - 12.15 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр Э.Тунгалаг |
| 17. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй /дадлага ажил/ | 12.15 – 13.00 | |
| Үдийн хоолны завсарлага | | 13.00-14.00 | |
| 18. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ | 14.00-14.45 | ЭМЧХ-ны гишүүн АУ-ны магистр М.Оюунчимэг |
| 19. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх /дадлага ажил/ | 14.45 – 15.30 | |
| 20. | Сургалтын дараах сорил | 15.30-15.40 | Чиглүүлэгчид |
| 21. | Сургалтын талаархи ярилцлага, хаалтын ажиллагаа | 15.40 – 16.00 | Чиглүүлэгчид |

Эрүүл мэндийн газрын даргын оны
... дугаар сарын ... өдрийн
... тушаалын гуравдугаар хавсралт



“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ”
АЯН, СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Нэр төрөл | Тоо | Хэмжих нэгж | Давтамж | Нэг бүрийн үнэ /₮/ | Нийт шаардагдах үнэ /₮/ |
|---------------------------------|--|-----|-------------|---------|--------------------|-------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Оролцогчид багш нар, зохицуулагчийн цайны зардал | 130 | Хүн /цай | 2 | 5000 | 650000 |
| 2 | Аннос 2x3 харьцаатай | 1 | ш | 1 | 72000 | 72000 |
| Хичээлийн хэрэглэгдэхүүн | | | | | | |
| 3 | Самбарын үзэг | 10 | Ширхэг | 1 | 3000 | 30000 |
| 4 | Бичгийн цаас | 1 | Боодол | 1 | 20000 | 20000 |
| 5 | Жижиг скоч | 2 | Ширхэг | 1 | 1500 | 3000 |
| 6 | Хавтас /аян/ | 9 | ширхэг | 1 | 6500 | 58500 |
| 7 | Нүхтэй уут | 4 | боодол | 1 | 18000 | 72000 |
| 8 | Хуулдаг фото цаас | 1 | боодол | 1 | 25000 | 25000 |
| 9 | Бүлгийн ажлын цаас | 1 | Ширхэг | 1 | 30000 | 30000 |
| Нийт | | | | | | 960.500 |

000